


Хүний нөөцийн удирдлагын ил тод байдал, 2025 оны бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, улсын хэмжээнд нийт төрийн байгууллагуудын тоог орон тоог 9 хувиар хассантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Төсвийн тухай хуулийн 14.2.12 “эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.” заалтын дагуу Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газрын агентлагын бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын орон тооны хязгаарыг 93 байсныг 84, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын нэгжийг 7 газар, 5 хэлтэстэй байсныг 6 газар, 5 хэлтэстэй болгон, нийгмийн даатгалын байгууллагын орон тооны дээд хязгаарыг 1477 байсныг 1341 байхаар тус тус баталсан байна.

Агентлагийн зохион байгуулалтын бүтэц



Дээрх тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/237 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, албан тушаалын жагсаалт, “Дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/238 дугаар тушаалаар дүүргийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалт, “Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлах тухай” А/239 дүгээр тушаалаар аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг тус тус шинэчлэн баталсан. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг 2024, 2025 оныг харьцуулан хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.Бүтцийн өөрчлөлт:

д/д	ХНХЯамны 2024 оны А/19 дүгээр тушаал /7 газар, 5 хэлтэс/	д/д	ГБХНХЯамны 2025 оны 163 дугаар тушаал /6 газар, 5 хэлтэс/
1	Дотоод аудит, мониторингийн газар	1	Дотоод аудит, мониторингийн газар
2	Захиргаа, удирдлагын газар	2	Захиргаа, удирдлагын газар
2.1	Хуулийн хэлтэс	2.1	Хуулийн хэлтэс
2.2	Сургалтын хэлтэс	2.2	Сургалтын хэлтэс
3	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар	3	Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар
3.1	Судалгаа, актуар тооцооллын хэлтэс	3.1	Судалгаа, актуар тооцооллын хэлтэс
4	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар	4	Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газар
4.1	Үйлчилгээ хөгжүүлэлтийн хэлтэс	4.1	Үйлчилгээ хөгжүүлэлтийн хэлтэс
5	Шимтгэл хураалт, удирдлага арга зүйн газар	5	Шимтгэл хураалт, удирдлага арга зүйн газар
6	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар	5	Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар
6.1	Тэтгэврийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хэлтэс	5.1	Тэтгэврийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хэлтэс
7	Хяналт шалгалтын газар	6	Хяналт шалгалтын газар
		6.1	Шимтгэлийн орлого, өрийн хяналтын арга зүйн хэлтэс
Орон тоо -93		Орон тоо -84	

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 6 газар, 5 хэлтэстэй болсноор зарим нэгжийн нэршил, чиг үүрэгт өөрчлөлт оруулж, чиг үүрэг, орон тоог дотоод нэгжүүдэд дахин хуваарилсан. Үүнд: Шимтгэл хураалт, удирдлага арга зүйн газрыг татан буулгаж, тус газрын чиг үүрэг, орон тоог Бодлого хэрэгжилт болон Хяналт шалгалтын газарт шилжүүлсэн. Сургалтын хэлтсийг татан буулгаж, Захиргаа, удирдлагын газрын үндсэн орон тоонд оруулсан байна.

Нийгмийн даатгалын байгууллагын зохион байгуулалтын нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталсантай холбоотойгоор зарим газар, хэлтэс татан буугдсан, нэршил өөрчлөгдсөн, чиг үүрэг өөр газарт шилжсэн, зарим албан тушаалын чиг

үүргийг нэгтгэсэн зэрэг шалтгаанаар 33 төрийн захиргааны албан тушаал, чиг үүргийг дахин хуваарилсан байна.

Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэж байгаатай уялдуулан 2024 оны Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл олгосны дагуу баталж, мөрдүүлж байгаа 133 албан тушаалын тодорхойлолтоос зохион байгуулалтын нэгж, албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүрэгт өөрчлөлт ороогүй албан тушаалд хамаарах хэвээр үлдээх 97, хүчингүй болгуулах 36 албан тушаалын тодорхойлолт байна.

Төрийн албаны зөвлөлийн 33 дугаар хуралдаанаар 33 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах зөвшөөрөл авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/337 дугаар тушаалаар тус газрын 18 албан тушаалын тодорхойлолтыг батлан албан хаагчдын томилгоо хийгдсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгох тухай” А/338 дугаар тушаалаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад шаардлагатай албан тушаалын тодорхойлолтыг бүтэц, зохион байгуулалттай уялдуулан батлах зөвшөөрлийг олголоо.